**7.2. “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд 2022-2023 онд тарьсан ногоон зурвасыг үргэлжлүүлж 1000 –с дээш ширхэг навчит модыг 1.0га талбайд тарьж ургуулан хашаалах.**

2022 оны 02 сарын 26-ны өдөр Орхон аймгийн Засаг дарга С.Батжаргалтай байгуулсан 2022/04 тоот “Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжин оролцох нийгмийн хариуцлагын гэрээ”, “Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн 2024 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2010 оны 04 сарын 14-ний өдрийн 62 дугаар “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” зарлигийн хүрээнд Орхон аймгийн Байгаль орчны газраас сонгож өгсөн талбай болох хүдэр тээврийн технологийн замын дагуу үргэлжлүүлэн 1,143.0 ширхэг навчит модыг 4 эгнээгээр 1.39 га талбайд тарьж ургуулан хашаажуулсан БОМТ-ний гүйцэтгэл 100%-тай биелэв. 2022-2024 онд тарьж ургуулсан моднуудын нөхөн тарилтад 157 ширхэг мөнгөлөг улиасаар нөхөн тарилт хийв. Мөн нэмэлтээр мод тарих ажлуудыг үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор хийсэн ба "Персиммон" ХХК-ийн талбайгаас баруун тийш 50м урт салхины хамгаалалтын зурвас хийж 300

ширхэг хайлаас, 42 ширхэг агч, мод үржүүлгийн газарт 50 ширхэг агч модыг тарив. 2024 оны намар мөн тус талбайд 400 ширхэг мөнгөлөг улиас тарьснаар 2024 онд нийт 2092 ширхэг навчит модын тарьж ургуулав.

*Хүснэгт 43. 2024 онд технологийн замын дагуу тарьж ургуулсан модны тоо, талбайн мэдээлэл*

| № | Координат | | код | Тарилт хийсэн хугацаа | Талбайн хэмжээ/га | Модны тоо | Хашааны урт (м) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | x | y | | | | | |
| 2024 оны хавар | | | | | | | |
| 1 | 434757.00 | 5426417.00 | 6-1 | 5 сар | 0.73 | 500.0 | 1,549.0 |
| 2 | 434756.00 | 5426430.00 | 6-2 | | | | |
| 3 | 434035.37 | 5426168.79 | 6-3 | | | | |
| 4 | 434039.00 | 5426161.00 | 6-4 | | | | |
| 2024 оны намар | | | | | | | |
| 5 | 433942.00 | 5426130.00 | 7-1 | 10 сар | 0.30 | 293 | 767.0 |
| 6 | 433940.00 | 5426136.00 | 7-2 | | | | |
| 7 | 433566.00 | 5426067.00 | 7-3 | | | | |
| 8 | 433571.00 | 5426058.00 | 7-4 | | | | |
| 9 | 433957.00 | 5426074.00 | 8-1 | | 0.36 | 350 | 777.0 |
| 10 | 433952.00 | 5426085.00 | 8-2 | | | | |
| 11 | 433581.12 | 5426013.64 | 8-3 | | | | |
| 12 | 433584.31 | 5426000.68 | 8-4 | | | | |
| **Нийт** | | | | | **1.39** | **1,143.0** | **3,093.0** |

*Зураг 48. 2024 онд технологийн замын дагуу тарьж ургуулсан модны байршил*



*Хүснэгт 44. 2024 онд үйлдвэрийн бүсийн ногоон байгууламжид тарьж ургуулсан модны тоо, талбайн мэдээлэл*

| № | Координат | | Хугацаа | Модны тоо | Хашааны урт (м) |
|---|---|---|---|---|---|
| | x | y | | | |
| 2024 оны хавар | | | | | |
| 1 | 436949.00 | 5427101.00 | 5 сар | 342 | Үйлдвэрийн бүсийн ногоон байгууламж "Персиммон" ХХК |
| 2 | 436894.00 | 5427101.00 | | | |
| 3 | 436897.00 | 5427095.00 | | | |
| 4 | 436948.00 | 5427097.00 | | | |
| 5 | 433674.765 | 5425338.146 | | 50 | Мод үржүүлгийн газар |
| 6 | 433661.165 | 5425436.753 | | | |
| 7 | 433811.687 | 5425429.575 | | | |
| 8 | 433825.057 | 5425330.980 | | | |
| 2024 оны намар | | | | | |
| 5 | 436951.00 | 5427096.00 | 10 сар | 400 | Үйлдвэрийн бүсийн ногоон байгууламж "Персиммон" ХХК |
| 6 | 436951.00 | 5427058.00 | | | |
| 7 | 436900.00 | 5427051.00 | | | |
| 8 | 436889.00 | 5427095.00 | | | |
| 9 | - | - | | 157 | Нөхөн таррилт |
| 10 | - | - | | | |
| 11 | - | - | | | |
| 12 | - | - | | | |
| **Нийт** | | | | **949.00** | |

*Зураг 49. 2024 онд үйлдвэрийн бүсийн ногоон байгууламжид тарьж ургуулсан модны байршил*



*Хүснэгт 45. 2024 онд тарьж ургуулсан тарьц суулгацын тоо ширхэг*

| № | Тарьц суулгацын нэр | Хэмжих нэгж | Хугацаа, тоо ширхэг | |
|---|---|---|---|---|
| | | | 5-6 сар | 10-11 сар |
| 1 | Мөнгөлөг улиас | ш | - | 1200 |
| 2 | Хайлаас | ш | 842 | - |
| 3 | Агч | ш | 50 | - |
| Нийт | | | 892 | 1200 |
| | | | 2092 | |

*Зураг 50. 2022-2024 онд технологийн замын дагуу тарьж ургуулсан модны талбайн байршил*




*Зураг 51. 2024 оны хаврын мод тарилт /2024 оны 5 сарын 10/*






*Зураг 52. 2024 оны намрын мод тарилт /2024 оны 10 сарын 03/*






*Зураг 53. 2024 оны үйлдвэрийн бүсийн ногоон байгууламжийн нэмэгдүүлэх мод тарилт*



Тарьсан модыг хашаажуулахдаа 3,093.0метр 10*10см нүдтэй 1.0м өндөр бэлчээрийн тор ашигласан ба тор тогтоох шонг ф-4.0см трубагаар шигтгэж хийв. Хашааны трубаг 1.7метрээр тасдаж, гагнаж 550 ширхэг шон бэлтгэх /газарт шигтгэхэд бэлтгэн нэг үзүүрийг ташуу зүсэх, богино трубаг нийлүүлж гагнасан ковшоор шон зоож, авто машинаар торыг чангалж татав.

*Зураг 54. Хашаажуулалт*



**7.3. Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд авто зам дагуу ногоон зурваст тарьж буй мод бут сөөгийн арилгаа хамгаалалтын сайжруулах**

Үйлдвэрийн бүсийн ногоон байгууламж болон "Тэрбум" мод хөтөлбөрийн хүрээнд тарьсан нийт модны усалгаа арчилгааг хийж хашаа хорооны бүрэн бүтэн байдлыг хамгаалж мал амьтан орохоос сэргийлэх, модны хашаа, замын дагуух хог хаягдлыг цэвэрлэх, мод үржүүлгийн газрын тарилт

усалгаа арчилгаа, хөрс боловсруулалтын ажлыг өдөр тутам хийх зорилгоор нийт 12 ажилтан шинээр ажилд авч ажиллуулав.

*Хүснэгт 46. “Тэрбум” мод хөтөлбөр 2024 онд хийгдэх ажлын хүн цагийн төлөвлөгөө*

| № | Ажлын нэр | хоног | хүн | хүн/цаг |
|---|---|---|---|---|
| 1 | 2024 оны хаврын мод тарилт /"Тэрбум мод" хөтөлбөр/ | 13 | 4 | 416 |
| 2 | Хаврын мод тарилт/салхины хамгаалалтын зурвас, үйлдвэрийн ногоон байгууламж нэмэгдүүлэх/ | 2 | 12 | 192 |
| 3 | Мод үржүүлгийн газарт /Хүлэмжид мод үржүүлэх/ | 15 | 12 | 1344 |
| 4 | Мод үржүүлгийн газарт /Гадна талбайд мод үржүүлэх/ | 18 | 12 | 1728 |
| 5 | Үйлдвэрийн бүсийн ногоон байгууламж нэмэгдүүлэх | 6 | 12 | 576 |
| 6 | Байгаль орчны удирдлагын албанд тогтмол хийгдэх туслах ажлууд | 70 | 5 | 2800 |
| 7 | 2024 оны намрын мод тарилт /"Тэрбум мод" хөтөлбөр/ | 10 | 5 | 400 |
| 8 | Өвлийн улиралд гүйцэтгэх ажил | 107 | 1 | 1656 |
| **Нийт** | | **241** | **12** | **9112** |

Зөөврийн усны эх үүсвэрээр үйлдвэрийн бүсийн мод болон зам дагуух салхины хамгаалалтын зурвасын модыг 7 хоногт 3 өдөр усалж байгаа бөгөөд хашааны бүрэн бүтэн байдал, мал амьтан орооцолдох, хашаа эвдэх эрсдэл, модны зэрлэг ургамлыг зулгаах, хортон шавжаас хамгаалах ариутгал зэргийг тогтмол хийж ажиллаж байна.

*Зураг 55. Технологийн замын дагуу тарьж ургуулсан модны арчилгаа хамгаалалт*
















**7.4. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжин оролцох нийгмийн хариуцлагын гэрээ", "Ногоон Эрдэнэт хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд навчит модыг мөчрийн тайраадасаар мод үржүүлгийн газарт ургуулах**

Манай мод үржүүлгийн газар “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд Баян-Өндөр сумаас олгосон Чингэлийн голын ард байрлах 1.5га газарт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2023 онд

хашаажуулалт, хүлэмжийн карказ босгох ажлыг гүйцэтгэж 2024 оны 5-6 сард хөрс бэлтгэл, үндсэн тарилтын ажлуудыг хийсэн ба стандарт шаардлага хангасан жишиг болохуйц мод үржүүлгийн газрыг байгуулаад байгаа юм.

Мод үржүүлгийн газарт 100.000 орчим 7 төрлийн навчит болон шилмүүст модны тарьц суулгацын үрээр болон стандарт мөчрийн тайраадасаар тарьж ургуулсан ба 2024 оны 9 сарын 5-ны өдөр нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулав.

#### 7.4.1. Мод үржүүлгийн газрын хөрс боловсруулалт

MNS 2418 : 2011 стандартын дагуу хөрс боловсруулалтыг хийсэн. Хагалгаа (Хагалгааг анжсаар шан ба хамар үүсгэлгүй хагалах ба хөрс жигд бутарч талбайн гадаргуу тэгш болж ургамлын үлдэгдлүүд доод давхаргад сайн булагдан ялзмаг үүсэх боломж бүрдүүлнэ).

**Сэндичлэгээ**: (Агротехникийн шаардлагаас хөмрөлттэй ба цант сэндчилүүрээр 6-14см гүнд хийнэ. Хөмрөгч сэндчилүүр нь хөрсийг сийрүүлэн хөл газрын ургамлыг огтолж хөрсний өнгөн үеийг хөмрүүлнэ).

**Борнойдолт**: (Хагалгааны дараа хөрсийг сийрүүлэн тэгшлэх, хөрсний өрөмтлийг устгах, агаарын солилцоог сайжруулах, хөрсний том хэсгийг бутлах, чийгийн ууршилтыг багасгадаг).

**Сийрүүлэлт**: (Хөрсний том хэсгийг бутлах, хөл газрын ургамлыг устгах өнгөн давхаргыг зөөллөх, агаарын солилцоог сайжруулах зэргээр үр суулгах тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэхээр хөрсийг 6-12см-ийн гүнд зохих хугацаанд сийрүүлсэн байна).

**Булдалт**: (Хөрсний чийгийн алдагдлыг багасгаж, хөрсний халалтад сайн нөлөө үзүүлнэ).

*Зураг 56. Мод үржүүлгийн газрын хөрс боловсруулалт*





*Хүснэгт 47. Мод үржүүлгийн газарт тарьж ургуулсан үр, мөчир*

| № | Үр, мөчрөөр тарьсан модны нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тарих нөхцөл |
|---|---|---|---|---|
| 1 | Мөнгөлөг улиас ( Populus alba L) | 10,000.0 | ш | Мөчрийн тайраадсаар ил болон далд үндэсний системтэйгээр гадна болон хүлэмжид |
| 3 | Бургас (Salix pentandra) | 10,000.0 | ш | |
| 4 | Хайлаас (Ulmus pumila L) | 3.0 | кг | Үрээр гадна болон хүлэмжид |
| 5 | Агч (Acer palmatum) | 3.0 | кг | |
| 6 | Нарс (pinus sylvestris L) | 1.0 | кг | |
| 7 | Шинэс (larix sibirica Ldb) | 2.0 | кг | |
| 8 | Шар хуайс (Caragana arborescens. Lam) | 2.5 | кг | |

*Зураг 57. Тарьц суулгац тарих, суулгах*



### 7.4.2. Мод үржүүлгийн газрын тарилт

**Мөнгөлөг улиас**: Нахиа задалсан эсэхийг нэг бүрчлэн шалгаж нахиа задарсан тайраадсын шууд тарилт хийсэн ба, нахиа задраагүйг үндэслүүлэгчид 24 цаг дэвтээн 5%-ийн KMnO4 уусмалд ариутгаж №1 хүлэмжид 6000 ширхгээр тарилт хийж үлдсэн 4000 ширхгийг гадна талбайд плянк татаж тарилт хийв.

**Бургас**: Нахиа задалсан эсэхийг нэг бүрчлэн шалгаж нахиа задарсан тайраадсын шууд тарилт гаргасан ба, нахиа задраагүйг үндэслүүлэгчид 12 цаг дэвтээн 5%-ийн KMnO4 уусмалд ариутгаж №2 хүлэмжид 6000 ширхгээр тарилт хийж үлдсэн 4000 ширхгийг гадна талбайд плянк татаж тарилт хийв.

**Хайлаас**: МУ-н үрийн мужлалын дагуу Хангал сум болон Орхон голоос түүж бэлтгэсэн 3.0кг үрийг хатааж цэвэрлэн №5 дугаар хүлэмжид тарилт хийв.

**Нарс, шинэс, шар хуайс:** Үрийг 5%-ийн KMnO4 уусмалд 8-10 цаг дэвтээж, шүүж аваад гумин 0.1 уусмалд 2 цаг дэвтээж шүүж аван хатааж сэврээгээд тарилт хийв.

**Агч**: Шууд тарилт хийсэн ба үлдсэн хэсгийг гадна талбайд тарив.

*Зураг 58. Мод үржүүлгийн газрын тарилт*








*Зураг 59. Тарилт хийснээс хойш 21 хоногийн дараах үр дүн*



### 7.4.3. Мод үржүүлгийн газрын усалгаа, арчилгаа

Хүлэмж тус бүрд чийг температур хэмжигч байрлуулсан ба чийг дулааныг тохиромжтой орчинд хянаж хэт халалт, хатах, гандах, ус дутах, ус ихдэх процессыг хянаж ажиллаж байна. Мөн хэт халалтыг бууруулах зорилгоор 70%-ийн нар бууруулагч торыг бүх хүлэмжүүдэд татав. Мөн зэрлэг ургамлыг тухай бүр нь түүж талбайг цэвэрлэж байна.

*Зураг 60. Мод үржүүлгийн газрын усалгаа, арчилгаа*








### 7.4.4. Мод үржүүлгийн газрын нээлтийн үйл ажиллагаа

“Ногоон Эрдэнэт” хөтөлбөр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин оролцох нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд 2032 он гэхэд 1.5сая мод тарьж ургуулан эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалж экологи байгаль хамгааллын ажлыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахад хувь нэмрээ оруулж, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилго бүхий “Эко үйлдвэр- Ногоон ирээдүй” мод үржүүлгийн газрын нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулав. Тус нээлтийн арга хэмжээнд АЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчин, уул уурхай хариуцсан мэргэжилтэн У.Чигэстэй, Байгаль орчны газрын дарга С.Жаргалсайхан, Ойн мэргэжилтэн Л.Батсайхан, Баян-Өндөр сумын засаг дарга Б.Баасансүрэн, Засаг даргын орлогч Ж.Энхсайхан, Баянцагаан багийн Засаг дарга Г.Наранжав нар мод үржүүлгийн газрын нээлтийн үйл ажиллагаанд ирж оролцов.

*Зураг 61. Мод үржүүлгийн азрын нээлтийн үйл ажиллагаа*













### 7.4.5. Мод үржүүлгийн газрын төлөвлөлт, үйл ажиллагааг сайжруулах зөвлөх үйлчилгээ

Манай компани нь Эко үйлдвэр-Ногоон ирээдүй мод үржүүлгийн газартаа МУИС-н багш, Доктор, Дэд профессор С.Гэрэлбаатар авч ирэн дараах чиглэлүүдээр зөвлөн туслах үйлчилгээ авч ажиллав. Тус зөвлөн туслах үйлчилгээг дараах үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллав.

Байгаль, цаг уурын нөхцөл, өнөөгийн бодит нөхцөлд үндэслэн, Мод үржүүлгийн газрын ерөнхий төлөвлөлт, аж ахуйн хэсгүүдийг байгуулах, талбайн зохион байгуулалтыг сайжруулах зөвлөмж бичих

Тарьц, суулгацыг тарьж ургуулах, арчлах, өвөлжүүлэх, бойжуулах, ойжуулалтад шилжүүлэх талаар ойн мэргэжилтэн, ойжуулагч нарт газар дээр нь зөвлөгөө өгөх

Мод үржүүлгийн газрыг салхи болон ургах орчны таагүй нөлөөллөөс хамгаалах үндсэн болон туслах зурвасын бүтэц, тарилтын схем, байгуулах аргачлалын талаар аргазүйн зөвлөмжөөр хангах

Мод үржүүлгийн газарт хүлэмжийн, бойжуулах талбайн, үрийн плантаци байгуулах талбайг оновчтой сонгох, орон зайн төлөвлөлтийг хийх

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэлтийн хүрээнд тус компани Орхон аймгийн нутагт тарьж ургуулах боломжтой модлог ургамлын зүйлийг сонгох, жагсаалт гаргах

Тарьц, суулгацын эрүүл байдлыг хянаж, өвчин, хортны голомт илэрсэн тохиолдолд тэдгээрийг таних, устгах, үр дагаврыг арилгах аргачлалаар хангах

Мод үржүүлгийн газрын талбайд мэргэжилтэн, ойжуулагч нарт тарьц суулгацыг эрчимтэй ургуулах талаар мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгөх, газар дээр нь ажиглалт хийх, хэмжилтийн мэдээлэл цуглуулах, зураглал хийх

*Зураг 62. Мод үржүүлгийн газрын ерөнхий төлөвлөлт*



“ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-ИЙН МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024ОН




## 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 8.1. Орхон аймагтай "Хамтран ажиллах гэрээ"-ний үүргийн хүрээнд үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулбал уг асуудлыг зохих журмын дагуу аймгийн ИТХ, Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх

“Зэс эрдэнийн хувь” ХХК нь Орхон аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргалтай 2024 оны 2 сарын 28-ны өдрийн 03/24 тоот “Орхон аймагтай хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан юм. Тус гэрээний хүрээнд байгаль орчны өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх, “Тэрбум” мод хөтөлбөрийг дэмжин ажиллах, хүүхэд залуучуудын оюуны боловсролыг дэмжих физикийн масс олимпиад зохион байгуулах, физикийн кабинет тохижуулах, хүүхдийн шатрын спортыг дэмжих болон бусад олон нийтэд чиглэсэн тогтвортой хөгжлийн арга хэмжээг АЗДГ-тай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж нийт 100,000,000.0 төгрөгийн төсвийг төлөвлөв.

Тус гэрээний 3 дугаар зүйлийн 3.1.1. дэх заалтад “Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад иргэн, хуулийн этгээдийн зүгээр хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх” тухай заалтыг оруулсан ба одоогоор манай компанийн үйл ажиллагаанд хууль бусаар саад учруулсан тохиолдол үүсээгүй хэвийн үйл ажиллагаа явуулж байна.

2024 онд Орхон аймаг, “Зэс Эрдэнийн хувь” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээг анх удаа байгуулсан ба 2024 оны "Хамтын ажиллагааны төлөвлөгөөний биелэлт"-ээ тайлагнаж 98.8% гүйцэтгэлтэйгээр хамгаалаа. Манай компани нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийн хүрээнд 13 иргэнийг түр ажлын байраар ханган цалингийн зардалд 122,1 сая төгрөгийг зарцуулав. Үүнээс таван иргэн байнгын ажлын байраар хангагдаж тус компанийн үндсэн ажилтан болсон байна. Мөн ерөнхий боловсролын 7-р сургуулийн “Химийн хичээлийн лабораторийн интерьерийн ажлын зураг” бэлэн болж, худалдан авах ажиллагаа болон гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах ажил үргэлжилж байна. “Физикийн судлагдахууны хичээлээр зохион байгуулсан “Анги нийтийн чанарын уралдаан”-нд ерөнхий боловсролын 19 сургуулийн 8, 11 дүгээр ангийн 110 бүлгийн 3242 сурагч хамрагдаж, мэдлэг ур чадвараа сорьж өрсөлдөв. Мөн “Эрдэнэт”

хаалгыг орой 18 цагаас өглөө 08 цаг хүртэл нарны эрчим хүч болон цахилгаан хосолсон хэлбэрээр гэрэлтүүлэх ажлыг гүйцэтгэсэн. "Зэс эрдэнийн хувь" ХХК орон нутгийн бизнес эрхлэгч иргэдээс нийт 1.4 тэрбум төгрөгийн бараа,бүтээгдэхүүн худалдан авсан байна.

*Зураг 63. Орхон аймагтай хамтран ажиллах*



### 8.2. Үйлдвэрийн бүсийн талбайн орчимд зуны улиралд нутаглаж буй малчин өрхүүдэд малаа хариулгатай байлгаж, төслийн талбайн нөлөөллийн бүсэд бэлчээрлүүлэхгүй байх талаар мэдэгдэл хүргэх, бүлгийн уулзалт хийх.

Монгол улсын ашигт малтмалын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1. “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасны дагуу төлөвлөн хэрэгжүүлэв. Манай үйлдвэрийн бүсийн орчимд өмчлөл эзэмшлийн газартай ард иргэд нутагладаггүй боловч зуны улиралд голын бэлчрээр айл өрхүүд мөн ихээр зусландаа гардаг. Манай компанийн зүгээр эдгээр айл өрхүүдэд бүлгийн уулзалт зохион байгуулан малаа хариулгатай байлгах, үйлдвэрийн талбай болон мод тарьсан талбай, модны хашаа сүйтгэхгүй байх анхааруулгыг байнга хүргүүлэн ажиллав. Мөн зарим айл өрхийг гүний худгаас ундны усаар хангаж ажилласан.

*Зураг 64. Малчдад зөвлөгөө өгөх, бүлгийн уулзалт*


МАЛЧДАД ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛСЭН БҮРТГЭЛ




ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ ХХК-ИЙН
КАТОДЫН ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР
№3

МАЛЧДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

2023.06.14 Орхон аймаг



## 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 401 дүгээр зүйл. “Соёлын өвийг хамгаалах” 401.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 402, 46 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ. 401.2.Ашигт малтмалын хайгуул хийхдээ

палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, зөвшөөрөл авахгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. 402 дугаар зүйл.Соёлын өвийг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг 402.1. “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь соёлын өвийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ, 402.1.2.Ашигт малтмал эрэх, хайх явцад олж илрүүлсэн соёлын өвийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хуульд заасны дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх ба тухайн өвийг холбогдох байгууллагад хадгалуулахаар шилжүүлэх үүрэг хүлээнэ” хэмээн заасан байдаг. “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу судалгаа, шинжилгээ, малталтын дүн болон палеонтологи, археологийн олдворыг сумын захиргаанд тайлагнах юм.

**9.1. Төслийн талбайд археологийн олдвор илэрсэн тохиолдолд хуулийн дагуу мэргэжлийн байгууллагад мэдээлж ажиллана. Археологийн тайланд тусгагдсан авран хамгаалах арга хэмжээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.**

Манай компани нь Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдлага хүмүүнлэгийн сургуультай байгуулсан АГГ/22-029 тоот гэрээний дагуу төслийн талбайд археологийн судалгааг мэргэжлийн баг хамт олноор гүйцэтгүүлэв. Үйлдвэрийн бүсэд археологийн олдвор илрээгүй.

*Зураг 65. Археологийн судалгааны тайлан*



БАТЛАВ
“ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ”-ИЙН
ЗАХИРАЛ ............ /А.ЭНХБАТ/

БАТЛАВ
“ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
............ /Б.МӨНХБААТАР/

**АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

Улаанбаатар хот | № АГГ-22/029 | 2022 оны 03 сарын 25 өдөр

[illegible]

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. [illegible]

**Хоёр. Гэрээний хугацаа**

2.1. [illegible]

**Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл**

3.1. [illegible]

3.2. [illegible]

**Дөрөв. Гүйцэтгэгч байгууллагын эрх, үүрэг**

1



ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ ХХК-ИЙН ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ [illegible] ТООТ КАДАСТРЫН ЛИЦЕНЗИЙН ТАЛБАЙН ДУГААР БҮХИЙ “САРХИА УУЛЫН ЗҮҮН ХЭСЭГ” ХЭМЭЭХ ТАЛБАЙД АРХЕОЛОГИЙН УРЬДЧИЛСАН ХАЙГУУЛ СУДАЛГАА ЯВУУЛСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

1. АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ
2. СУДАЛГААНЫ АНГИЙН АЖЛЫН УДИРДАМЖ
3. АРХЕОЛОГИЙН АВРАН ХАМГААЛАХ ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ ЗӨВШӨӨРЛИЙН ХУУЛБАР
4. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ЯВЦАД ОЛДСОН ДУРСГАЛЫН ГЭРЭЛ ЗУРАГ ТАЙЛБАР
5. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
6. СУДАЛГААНЫ АНГИЙН АЛБАН ЁСНЫ ДҮГНЭЛТ
7. ХАВСРАЛТ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:
ДОКТОР............ Л.ЭРДЭНЭБОЛД
ДОКТОРАНТ............ Э.УРТНАСАН
МАГИСТР............ Г.АМАРСАЙХАН

АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙГУУЛЛАГА:
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ
ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР
ШУТИС-ийн VБАЙР, 1-Р ХОРОО, 2-Р ХОРОО,
БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, ИХ ТОЙРУУ, ШХ 313,
УЛААНБААТАР, МОНГОЛ УЛС
ХОЛБОО БАРИХ УТАС
976-99057229

УЛААНБААТАР ХОТ 2021

**9.2. Төслийн талбайд палеонтологийн олдвор илэрсэн тохиолдолд хуулийн дагуу мэргэжлийн байгууллагад мэдээлж ажиллана. Палеонтологийн тайланд тусгагдсан авран хамгаалах арга хэмжээний зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.**

Манай компани нь Шинжлэх ухааны академийн Палеонтологийн хүрээлэнтэй байгуулсан АГГ/22-030 тоот гэрээний дагуу төслийн талбайд палеонтологийн судалгааг мэргэжлийн баг хамт олноор гүйцэтгүүлэв..

*Зураг 66. Палеонтологийн судалгааны тайлан*





“ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ” ХХК-д

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ПАЛЕОНТОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

ЗАХИРАЛ, ДОКТОР Ж.ЦОГТБААТАР

2022000075

Шинжлэх ухааны академийн Палеонтологийн хүрээлэнгийн 2022 оны 04 сарын 27-ны Т/23 тоот “Палеонтологийн хайгуул, судалгааны ажлын дүгнэлт”-ээр “Тайланд дурдаж дүгнэлт хийснээр танай компанийн талбайн ихэнх хэсгээр пермийн настай Сэлэнгэ бүрдлийн интрузив чулуулаг тархсан байна. Бидний хийсэн палеонтологийн хайгуул, тандан судалгаагаар гүний магмын гаралтай интрүзив чулуулаг илэрч байсан тул амьтан ургамлын чулуужсан үлдэгдэлгүй юм. Дээрх хурдас чулуулгаас эртний шим ертөнцийн олдвор илрээгүй тул танай компани цаашид тусгай зөвшөөрлийн ажил явуулахад манай зүгээс татгалзах зүйлгүй гэж үзлээ” хэмжээн дүгнэлтэд дурдсан байна. Үйлдвэрийн бүсэд палеонтологийн олдвор илрээгүй. Түүх, шинжлэх ухаан, соёлын үнэт зүйл болох газар, хөрс нь улсын хамгаалалтад байх бөгөөд олдвор нь улсын өмч болдог. Археологи ба палеонтологийн үнэт дурсгалт зүйлс нь аль болох байгалийнхаа байсан газарт нөөцлөгдөн хадгалагдах зарчимтай гэж хуульд заасан байдаг.

## 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Осол” гэж тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл, аваар осол, хүний алдаатай үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх системийн хэвийн бус ажиллагааг хэлэх бөгөөд төслийн үйл ажиллагааны хүрээнд ирээдүйд үүсэж болзошгүй осол эрсдэлийг урьдчилсан таамаглан тодорхойлж байгаа болно.

“Байгалийн аюул” гэж хохирол, сүйрлийг өөртөө агуулж байж болзошгүй, биосферт явагддаг байгалийн үзэгдэл эсвэл үйл явцыг хэлэх бөгөөд төслийн үйл ажиллагааны хүрээнд ирээдүйд үүсэж болзошгүй осол, байгалийн гамшгийг урьдчилан таамаглан тодорхойлж байгаа болно. Төслийн үйл ажиллагааны явцад хүний үйл ажиллагаа, техник технологи, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл болон байгалийн гамшиг, газар хөдлөл, үер, аянга цахилгаан хүчтэй шороон болон цасан шуурга зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр химийн бодисын осол эрсдэлээр үүсэж болзошгүй юм.

### 10.1. Химийн бодисын тусгай зөвшөөрлийн дагуу ашиглаж буй химийн бодисын орлого зарлагын тайланг хуулийн хугацаанд тайлагнах, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн дагуу химийн бодисын тайлан мэдээ, аюултай хог хаягдлын тайлан мэдээг Орхон аймгийн БОГ-т хүргүүлж байна. Мөн ГХУСАЗСЗ-ийн даргын 2024 оны 04 сарын 08-ны өдрийн “Химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис,

тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийх ажлын удирдамж”, Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын улсын байцаагчийн 2024 оны 04 сарын 22-ны өдрийн 01-25-01/59/17 тоот “Зөрчил арилгах тухай” албан шаардлага, Орхон аймгийн “Терроризмтэй тэмцэх ажлыг зохион байгуулах салбар зөвлөл”-ийн “Химийн хортой болон аюултай бодис, цацрагийн үүсгүүр, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийх ажлын удирдамж”-ын дагуу хяналт шалгалтад шалгуулав.

*Зураг 67. Тайлан мэдээ, хяналт шалгалт*
















БАТЛАВ

ОРХОН АЙМГИЙН ТЕРРОРИЗМТЭЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д.ЭНХТҮВШИН

2024 оны 10 дугаар сарын -ний өдөр

ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС, ЦАЦРАГИЙН ҮҮСГҮҮР, ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН БАЙДАЛД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

2024.10.21 Эрдэнэт хот

Зорилго: "Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль", "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам", "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль", "Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм", "Цөмийн энергийн тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавих, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, нэгдсэн мэдээ, мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийх, нөхцөл байдлыг тодорхойлох, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

НЭГ. ШАЛГАЛТ ХИЙХ ХУГАЦАА

Шалгалт 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 24-ний хооронд явагдана.

ХОЁР. ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН

- ТЕГ-ын Орхон аймаг дахь газрын ахлах, ахмад Н.Одонхүү.
- АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, захиргааны хэм хэмжээний акт хариуцсан мэргэжилтэн М.Бимбадорж
- ОБГ-ын цацраг химийн хордлогоос хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэн, хошууч Б.Өлзийсайхан
- Орхон аймаг дахь цагдаагийн газрын эрүүгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч О.Жинжбаа
- БОАЖГ-ын байгаль орчны хяналтын улсын байцаагч Т.Нямсүрэн
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн хууль ажлын хяналтын улсын байцаагч Т.Батцэцэг.
- БОАЖГ-ын орчны бохирдол, хог хаягдал, химийн бодис, байгалийн гамшиг хариуцсан мэргэжилтэн П.Энхсайхан.
- БШУГ-ын цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч Б.Нарангоо.
- УЦУОШТ-ийн чанарын менежер Ц.Энхтогос.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.14-т заасан тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, устгах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно, мөн хуулийн 13 дугаар зүйл болон 13 дугаар зүйлийн 13.7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтөлж, тайлан мэдээг сум, дүүргийн Засаг даргад жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор, төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 1 дүгээр сард багтаан хүргүүлнэ гэж заасны дагуу дараах үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажиллаж байна

### 10.2. Химийн бодисын хадгалалт, ашиглалтын горимыг зөрчихгүй байх, Химийн бодисын агуулахад зохих журам, стандартын дагуу хяналт тавьж бодисын хадгалалт, тээвэрлэлтийг зохих журмын дагуу гүйцэтгүүлэх

Манай компанийн ашиглаж буй химийн бодисын агуулах нь MNS 6458:2014 стандарт, БНбД 31-19-10, 2010 барилгын норм ба дүрэм шаардлагыг хангасан Монгол улсын Мэргэжлийн хяналтын Улсын Ахлах байцаагчийн 2022 оны 08 сарын 12-ны өдрийн 14-04-004/132 "Баталгаажуулах үйл ажиллагаа хийсэн тухай" дүгнэлт, Мэргэжлийн хяналтын Улсын Ахлах байцаагчийн 2022 оны 07 сарын 28-ны өдрийн 14-06-036/121 "Ачаа тээврийн авто машины ашиглалтын тухай" дүгнэлт, БОАЖЯ-ны 2022 оны 2 сарын 05-ны өдрийн 0002082 тоот "Химийн хорт бодис импортлох ашиглах зөвшөөрөл", БОАЖЯ-ны 2023 оны 02 сарын 10-ны өдрийн 0002369 тоот "Химийн хорт бодис ашиглах зөвшөөрөл"-өөр үйл ажиллагаа явуулж байна. Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 5.2.10 дахь заалтын дагуу химийн хорт болон аюултай химийн бодисын асуудал хариуцсан нярав ажиллахаас гадна компанийн ХАБЭАБОХ-ээс зохих журам, стандартын дагуу хяналт тавьж ажилладаг.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 15-р зүйл 15.6.3 дах заалтын дагуу "Химийн хорт болон аюултай бодис ашиглах, импортлох хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй

Химийн хорт ба аюултай бодисын тухай хууль 17-р зүйл 17.1 дэх заалт, Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 3.2 дахь заалтын дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хүрээнд химийн хорт болон аюултай бодис болон агуулахад эрсдэлийн үнэлгээ хийлгүүлсэн

Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2.1.5 дахь заалтын дагуу “Болзошгүй осол аваарын үед ажиллах ослын төлөвлөгөө”-г боловсруулж, батлуулсан

Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2.1.2, 2.1.4 дахь заалтын дагуу “Аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г химийн бодисын хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн ашиглах үйл ажиллагаа нэг бүрээр боловсруулж, батлуулан, өдөр тутмын үйл ажиллагаанд ашигладаг

Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 13-р зүйл 13.7 дах заалтын дагуу Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт зарцуулалтын тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн

*Зураг 68. Химийн бодисын хадгалалт*



### 10.2.1. Химийн бодисын агуулах

Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014 Агуулах нь байгалийн механик болон автомат агааржуулалтын системийг суурилуулсан, Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014 Агуулах нь хадгалж буй бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материал, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэлтэй, Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014 Аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ болон шаардлагатай утасны жагсаалтыг нүдэнд харагдахуйцаар байрлуулсан

### 10.2.2. Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ болон шаардлагатай утасны жагсаалтыг нүдэнд ил харагдахуйцаар байрлуулах

Химийн хорт болон аюултай бодисын агуулахад “Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг. MNS 5029:2011”-д заасан анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тэмдэглэгээ

Хориглох тэмдгийг нүдэнд ил харагдахуйцаар байрлуулав.

Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх шаардлагатай талаарх тэмдэглэгээг байрлуулав.

*Зураг 69. Химийн бодисын агуулахын тэмдэг тэмдэглэгээ*













### 10.2.3. Химийн бодисын тээвэрлэлт

Манай компани нь Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 сарын 23-ны өдрийн А/12 тоот “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх ашиглах устгах” журмын дагуу химийн бодисын хадгалалт, ашиглалтын горим, химийн бодисын агуулахад мөрдөх стандарт, дүрэм, журмын хэрэгжилт, химийн бодисын хадгалалт хамгаалалт, химийн бодисын аюулгүй ажиллагаа тээвэрлэлттэй холбоотой бүх ажилбаруудыг зохион байгуулж ажилладаг.

*Зураг 70. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх ашиглах устгах журам*


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ




"ЗЭС ЭРДЭНИЙН ХУВЬ" ХХК-ИЙН ХИМИЙН БОДИС АШИГЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ, УСТГАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Лабораторийн хэрэглээний химийн бодисуудын ачилт тээвэрлэлтийн үйл ажиллагааг химийн бодис нийлүүлж буй тусгай зөвшөөрөл бүхий компаниас хариуцан гүйцэтгэдэг ба химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан заавраын дагуу тээвэрлэлтийг хийдэг. Үйлдвэрт ашиглагддаг хүхрийн хүчлийг Орхон аймгийн Баян-Өндөр суманд байрлах ОТК ХХК-ийн төмөр замын терминалд нийлүүлэгч буюу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн компани вагон цистернаар тээвэрлэн ирэх ба вагон-цистерна нь юүлэх, савлах ажиллагааг сайтар хангасан тоноглолтой, хүхрийн хүчил буулгах хаалт, хавхалганы диаметр болон хэмжээ нэгэн жигд аюулгүй ажиллагааг хангасан, аюулын шинж чанарын тухай санамж байршуулсан байна. Зэс эрдэнийн хувь ХХК-иас техникийн аюулгүйн шаардлага хангасан зориулалтын буюу хүхрийн хүчлийн тээвэрлэхэд тусгайлан бэлтгэсэн тээврийн хэрэгслээр зөвхөн тогтоосон маршрутын дагуу тээвэрлэн үйлдвэрийн талбайд байрлах хүхрийн хүчлийн агуулахад хадгалдаг. Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх маршрутыг аль болох замын хөдөлгөөн багатай, тэгш, бартаа саад бага байхаар сонгож хэзээ хаанаас хэрхэн тээвэрлэх талаарх мэдээллийг тухайн орон нутгийн онцгой байдлын асуудал эрхэлсэн болон цагдаагийн байгууллагад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах ба байдлын хангуулдаг. Химийн бодисын тээвэрлэлтийн үед батлагдсан маршрутын дагуу дуут дохиогоор тоноглогдсон цагдаагийн машин цуваag тэргүүлж явах ба цуваaны ард компанийн ХАБЭА-н ажилтан цуваг түгжиж үйлдвэрийн бүсэд аюултай ачааг эрсдэлгүй авч ирдэг.

### 10.3. Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол, ойлгомжтой хэлбэрээр өгөх, аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллах зан үйлд сургах, химийн бодисын хор, аюулыг таниулах заавар, зөвлөгөө өгөх, ажиллагсдын мэдлэг, хандлагыг сайжруулах

Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2.1.6, 2.1.8 дахь заалтын дагуу ажлын байранд химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсад болон нийт ажилчдыг үйлдвэрийн бүсэд үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах, хамгаалах багаж хэрэгслийг ашиглах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургаалтанд жил бүр хамруулж байна.

“Зэс эрдэнийн хувь” ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтэс нь жил бүр мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан сургалтуудыг зохион байгуулдаг ба “Эрдэнэт цогцолбор дээд сургууль”, “Монкран Консалтинг” ХХК мэргэжлийн байгууллага, Орхон аймгийн “Улаан загалмайн хороо” зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

2024 онд 193 ажилтан “Эрдэнэт цогцолбор дээд сургууль”-д  ХАБЭА-ын 12 багц цагийн сургалтад хамрагдсан.

2024 онд 193 ажилтан “Эрдэнэт цогцолбор дээд сургууль”-д “Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны 17 багц цагийн сургалтад хамрагдсан.

Орхон аймгийн “Улаан загалмайн хороо”-ны Анхны тусламжийн сургалт”-нд  нийт 15 ажилчин хамруулав.

“Монкран Консалтинг” ХХК мэргэжлийн байгууллагаас “Техник тоног төхөөрөмжийн чадамжийн сургалт”-нд 37 ажилтныг хамруулав.

2024 онд ХАБЭАБО-ны хэлтсээс нийт ажилчдад давхардсан тоогоор 941 удаагийн сургалт зохион байгуулж химийн бодистой харьцаж ажиллах, үүсэж болзошгүй эрсдэлийг таних мэдэх,  урьдчилан сэргийлэх, компанийн ХАБЭАБО-ны дүрэм журмыг сахин мөрдөж аюул эрсдэлгүй ажиллах мэдлэг мэдээллийг олгох сургалт зохион байгуулсан.

Үйлдвэрийн бүсэд бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа туслан гүйцэтгэгч компаниудын нийт 280 гаруй ажилчдад урьдчилсан болон давтан зааварчилгааг сар бүр тогтмол өгч байна.

Зураг 71. Ажилчдын чадамжийн сургалтын гэрчилгээ




Зураг 72. Ажилчдын ХАБЭА-ын сургалтын сертификат




Зураг 73. Нийт ажилчдын сургалт, сертификат




ШОТГОНБИЛЭГИЙН НЭРЭМЖИТ
"ЭРДЭНЭТ ЦОГЦОЛБОР" ДЭЭД СУРГУУЛЬ

EiT
SINCE 1975

СЕРТИФИКАТ

(Овог, нэр)

Химийн хорт ба аюултай бодистой харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны ХАБЭА-н сургалтад хөтөлбөрийн дагуу суралцаж, шалгалтыг амжилттай өгсөн тул гэрчилгээ олгов.

Дугаар: 019

ЗАХИРАЛ ДЭЭРГЭТХҮҮ


ХИМИЙН ХОРТ БА АЮУЛТАЙ БОДИСТОЙ ХАРЬЦАЖ АЖИЛЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

| Хичээлийн нэр | Цаг |
|---|---|
| [illegible] | 1 |
| [illegible] | 1 |
| [illegible] | 2 |
| [illegible] | 2 |
| [illegible] | 2 |
| [illegible] | 2 |
| [illegible] | 1 |
| [illegible] | 1 |
| [illegible] | 1 |
| [illegible] | 1 |
| [illegible] | 1 |
| [illegible] | 1 |
| [illegible] | 1 |
| Шалгалт үнэлгээ | |
| НИЙТ 17 цаг | |





Зураг 74. Ажилчдын анхны тусламжийн сургалт, сертификат


ОРХОН УЛААН ЗАГАЛМАЙН ХОРОО

Сертификат

ЭРХЭМ ХҮНДЭТ

Балсанжав овогтой Амарсанаа

Монголын улаан загалмай нийгэмлэгийн нийгмийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрөөс батлагдсан АНХНЫ ТУСЛАМЖИЙН СУРГАЛТАД хамрагдсан тул гэрчилгээ олгов.

Д.ТУЯГАЛАГ
ОРХОН УЛААН ЗАГАЛМАЙН ХОРООНЫ ДАРГА

2024.04.19







*Зураг 75. Химийн бодисын аюулгүй ажиллагаа дотоод сургалт*



### 10.4. Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлсийн талаар бодит мэдээллээр ажилчдын хангах, аюулгүй ажиллах зан үйлд ажилчдыг сургах

Химийн хортой болон аюултай бодистой харьцан ажилладаг ажилчдад сар болгон химийн бодисын хэмжилтийн үр дүнг хэлтэс нэгжүүдийн ИТА-аар дамжуулан мэдээлэлдэг ба ажлын байрны сөрөг хүчин зүйлсийг таньж илрүүлэн түүнээс шалтгаалах өвчин эмгэг эрсдэлүүдээс хэрхэн урьдчилан сэргийлэх, илрэх шинж тэмдгийн талаар мэдлэг мэдээлэл олгож байна.

**Эрүүл ахуйн дотоод хяналт мониторинг**: “Зэс эрдэнийн хувь” ХХК-нь хөдөлмөрийн эрүүл ахуйн дотоод мониторингийг сар бүр тогтмол үнэлж тодорхойлдог бөгөөд энэхүү тайланд 2024 оны 06-р сард гүйцэтгэсэн хандлах үйлдвэр болон электролизийн үйлдвэрийн химийн бодисын хэмжилтийн утгыг тусгалаа. Хэмжилтийн утгыг илэрхийлэх нэгж: Химийн хүчин зүйл (мг/м3; ppm)

*Хүснэгт 48. Химийн бодисын хэмжилт 2024 оны 6 сар*

| Д/д | Ажлын байр | Химийн хүчин зүйлс | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Угаарын хий (CO) | Хүхэрлэг хий (SO2) | Аммиак (NH3) | Азотын давхар исэл(NO2) |
| | | MNS 4990:2023 | MNS 4990:2023 | MNS 4990:2023 | MNS 4990:2023 |
| | | 20мг/м3 | 2мг/м3 | 17мг/м3 | 0.38 мг/м3 |
| 1 | Хандлах үйлдвэр | 0 | 0.2 | 0 | 0 |
| 2 | Электролизийн үйлдвэр | 2 | 0.2 | 7 | 0 |

Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтэд ашигласан багаж:  Drager X-am 5600

Электролизийн ваннд химийн бодисын ууршилт өмнөх сарын хэмжилттэй харьцуулахад буурсан байгааг илтгэж байна. Химийн бодисын хэмжилтээр MNS 4990:2023 стандартаас давсан бохиролгүй байна.

**Эрүүл ахуйн гадаад хяналт мониторинг**: Улаанбаатар хот, Ус цаг уур орчны шинжилгээний газрын БОХЗТЛ-иос мэргэжлийн инженер ирж үйлдвэрийн ажлын байрны агаарын чанарын шинжилгээг 3 цэгт, нарийн ширхэглэгт тоос, том ширхэглэгт тоос, нийт тоос, дуу шуугиан үзүүлэлтүүдээр  MNS 4990:2015, MNS 5002:2000  стандартын дагуу гүйцэтгэв.

Хэмжилтийн утгыг илэрхийлэх нэгж: Химийн хүчин зүйл (мг/м3;)

Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтэд ашигласан багаж: Dust Trak™ DRX Aerosol Monitor

*Хүснэгт 49. Химийн бодисын хэмжилт 2024 оны 5 сар*

| д/д | Ажлын байр | Химийн хүчин зүйлс | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **Нарийн ширхэглэгт тоос (PM2.5)** | **Том ширхэглэгт тоос (PM10)** | **Нийт тоос TSP** | **Дуу чимээ** |
| | | **MNS 4990:2015** | **MNS 4990:2015** | **MNS 4990:2015** | **MNS 5002:2000** |
| | | **3.0 мг/м3** | **мг/м3** | **2.0 мг/м3** | **85 ДБА** |
| 1 | Уурын зуух ажлын байр | 0.071 | 0.092 | 0.228 | 74 |
| 2 | Хандлах үйлдвэр | 0.088 | 0.164 | 0.265 | 72 |
| 3 | Электролизийн үйлдвэр | 0.061 | 0.077 | 0.107 | 65 |

Шинжилгээний дүнгээс үзэхэд үйлдвэрийн дотоод орчин, ажлын байруудад нарийн ширхэглэгт тоос (PM2.5), том ширхэглэгт тоос (PM10), нийт тоос TSP, дуу чимээний бохирдол үүсээгүй буюу MNS 4990:2015, MNS 5002:2000 стандартын шаардлага хангаж байна.

*Зураг 76. Үйлдвэрийн химийн бодисын хэмжилт (гадна)*


ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ
БАЙГАЛЬ
СОРИЛТЫН ДҮН



### 10.5. Эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудын өртөлтийг бууруулсан арга хэмжээ

Мөн сар бүр үйлдвэрийн эрүүл ахуйн дотоод мониторингийн хэмжилтийг хэмжиж ажилчдад танилцуулан ажил амралтын цагийг зохицуулсан дүгнэлт, зөвлөгөө боловсруулж, мэдээлэл хүргэж ажилчдад шаардлагатай сургалт мэдээ мэдээллийг ээлж болгон дээр нь олгож танилцуулж байна. Дотоод мониторингийн физик хэмжилтэд нийт 6 үзүүлэлтийг тодорхойлсон ба үүнд:

- Харьцангуй чийглэг
- Гэрэлтүүлэг
- Агаарын урсгалын хурд
- Агаарын температур
- Ажлын байрны шуугиан

Химийн бодис гэсэн үзүүлэлтүүдийг FLUS ET-965 болон Drager X-am 5600 багажийг ашиглан хэмжилтийн утгуудыг үнэлж байна. Хагас нүүрний фильтертэй багын фильтер олголтыг 14 хоног тутамд сольж, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуульд заасанчлан ажил олгогчийн үүрэг хариуцлагаа биелүүлэн ажилчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж ажиллаж байна. Ажлын онцлог нөхцөл байдлаас шалтгаалан фильтертэй багын олголтын хоногийн давтамж өөр өөр байдаг. Мөн үйлдвэрийн ажилчдадаа химийн бодис болон нэг бүрийн хамгаалах хэрэгслийн талаар ээлж болгон дээр мэдлэг мэдээлэл хүргэдэг. 2024 оны 9-р сард манай компани хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2023 онд хийлгэсэн компаниараа дахин хийлгэж үйлдвэрийн сөрөг хүчин зүйлсийг тодорхойлуулан боловсруулж өгсөн дүгнэлт зөвлөмжийнх нь дагуу шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй түргэн шуурхай авч хамтран ажиллахаар төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.

*Зураг 77. Үйлдвэрийн химийн бодисын хэмжилт(дотор)*





### 10.6. Хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйлд өртөж ажилладаг ажиллагсдын дархлааг дэмжих, витаминжуулах

Манай компани нь ажилчдын эрүүл мэндийг нэн түрүүнд хамгаалах зорилтыг нэн тэргүүнд тавьж ажилласаар ирсэн бөгөөд үйлдвэрийн нийт ажилчдын дархлааг дэмжиж витаминжуулах ажлыг улирал тутам зохион байгуулдаг. 2024 оны 5 сард витаминжуулалтын аяны хүрээнд ажилтан бүрт витамин С 1000мг , витамин Д 2000Ед , Билобил 3 төрлийн бэлдмэл хамт 212 ажилтанд олгосон бол

2024 оны 11 сард омега-3 fish oil 1200mg, витамин комплексоор нийт 263 ажилтны дархлааг дэмжсэн.

*Зураг 78. Ажилчдад олгосон витаминууд*




### 10.7. Ажилчдыг эрүүл мэндийн төлөвлөгөөт үзлэгт хамруулах

Манай компани нь Эрүүл мэндийн сайдын А/340 тушаалын дагуу ажилтан бүрийг ажилд авахаас өмнө урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажлын байранд тэнцсэн дараа ажилд авдаг ба ажилд орсон хугацаанаас эхлэн жил бүр хугацаат үзлэгт компанийн зардлаар хамруулдаг .

“Зэс эрдэнийн хувь” ХХК, “Эрдэнэт медикал эмнэлэг” ХХК, “Амар даатгал” ХХК -ын хооронд 2023 оны 11 сарын 30-ны өдөр байгуулсан “Эрүүл мэндийн хугацаат үзлэг шинжилгээ хийх, үйлчилгээ үзүүлэх гэрээ”, “Амар даатгал” ХХК-тай байгуулсан 2024 оны 09 сарын 21-ний “Даатгалын гэрээ”-ний дагуу нийт 206 ажилтан эрүүл мэндийн даатгалд хамруулж “Эрдэнэт медикал” эмнэлэгт эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамрагдаад байна.

*Зураг 79. Ажилчдын эрүүл мэндийн үзлэг шинжилгээ*



### 10.8. Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл олгох, хэрэглэх, цэвэрлэх, устгах арга хэмжээ

Манай компани нь Гүйцэтгэх захирлын 2024 оны 1 сарын 30-ны А/020 тоот “Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл олгох, хэрэглэх, цэвэрлэх, устгах журам”-ыг батлан журмын дагуу нийт ажилчдыг өвөл, зуны ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /цаашид НБХХ гэх/, тусгай хамгаалах хэрэгсэл /цаашид ТХХ гэх/-ээр бүрэн хангаж ашиглах норм, хадгалах, цэвэрлэх болон устгах зэрэг бүхий л үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрийн талбайд ажиллаж буй нийт ажилчдыг ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу зөв хэрэглүүлэх, хөдөлмөрийн эрүүл мэндийн талаарх мэдээллээр тогтмол хангаж, эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудын өртөлтийг бууруулан ажиллаж байна.

**Хамгаалах хэрэгслүүдийн мэдээлэл**:

**“Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл**” гэж ХАБЭА-н тухай хуулийн 3.1.12-т заасан үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилтныг хамгаалах зориулалт бүхий стандартад нийцсэн доорх хэрэгслүүдийг хэлнэ.

**Толгойн хамгаалах хэрэгсэл**: Толгой хамгаалах хэрэгсэл (цаашид “каск” гэх) гэдэг нь гадны биет (дээрээс юм унах, мөргөх гэх мэт), халуун хүйтний нөлөө, цахилгаанаас толгойг (гадны халдлагаас ) хамгаалах хэрэгсэл юм. Дээрээс юм унах болон мөргөх аюул бүхий ажлын байранд каскны бүчийг бүчилсэн байх шаардлагатай.

**Нүд хамгаалах хэрэгсэл**: Нүд рүү гадны биет үсэрч гэмтээх аюул бүхий бүх газруудад тохирох хамгаалалтын нүдний шилийг сонгож зүүнэ. Жишээ нь: Материал тастах ажил, гагнуурын ажил, зорогч төхөөрөмжүүд дээр ажиллах, нүд гэмтээх шингэн болон хуурай зүйлүүдээс хамгаалах.

**Хөл хамгаалах хэрэгсэл**: Ажлын гутал нь хурууны ган хамгаалалтай, 200 Жоуль хүртэлх механик биетийн цохилтоос хөлийг хамгаалах чадвартай, цахилгаан хүчдэлээс хамгаалсан, ул нь зузаан халтирдаггүй, хугардаггүй, хөлддөггүй, хайлдаггүй шахмал резин материалаар хийгдсэн, хоншоор, уландаа ган эсвэл гантай дүйцэхүйц материалын оруулгатай, гэрэл ойлгогч цацруулагчтай, зуузай нь суудаггүй давхар оёдолтой байна.

**Гар хамгаалах хэрэгсэл**: Ажилтнууд гар гэмтээх, бохирдох ажил гүйцэтгэхдээ тухайн ажлын онцлогт тохирсон бээлийг сонгож заавал өмсөж хэрэглэнэ. Үйлдвэрийн талбайд, аливаа ажил хийхэд ажлын нэг удаагийн бээлий өмсөх бөгөөд цахилгаанчин нь цахилгааны ажил гүйцэтгэх үед заавал цахилгаан гүйдлээс хамгаалсан бээлийг өмсөнө. Өндөр хүчирдлийн ажил хийх үед тухайн өндөр хүчдэлийн вольтоос хамгаалсан бээлийг сонгож өмсөнө.

**Сонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл**: Дуу шуугиан ихтэй газар болон дуу шуугиан их гэсэн тэмдэг бүхий газруудад сонсгол хамгаалах хэрэгсэл болох чихний бөглөө (эсвэл чихэвч)-г заавал хэрэглэнэ. Сонсголын эрхтнийг хамгаалах зориулалтын хэрэгслийн оронд дуу шуугианыг бууруулах зориулалтын бус чихэвч (чихэвчний хөгжим, чихийг хүйтнээс хамгаалах чихэвч) ашиглахыг хориглоно.

**Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгсэл**: Үйлдвэрлэлийн тоосжилт ихтэй орчинд амьсгалын эрхтнийг хамгаалах зорилгоор 2.5 PM шүүлтүүр бүхий хошуувч, N95 загварын 1 удаагийн амны хаалтыг хэрэглэнэ. Химийн лаборатори, Өдрийн хэрэглээний агуулах, Урвалжийн агуулах, Хандлалтын үйлдвэр, Электролизийн үйлдвэрт 3M загварын тоос болон химийн хорт бодис шүүх хамгаалалт фильтертэй нүүрэвч, маск зүүнэ. Хошуувчийг зүүсэн үед битүүмжлэлийг шалгана, шүүлтүүрийг бохирдсон үед заавал солино.

